

УЛС ТӨРИЙН НАМЫН СОНГУУЛИЙН КАМПАНИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЗАРИМ АСУУДАЛД

Монголын Нээлттэй нийгэм хүрээлэнгээс “Улс төрийн намын болон сонгуулийн кампанийн санхүүжилт сэдвээр 2003.10.31-нд зохион байгуулсан уулзалт ярилцлагад Монгол улсын Сонгуулийн ерөнхий хорооны дарга, доктор, профессор **Ж.Ядамсүрэнгийн** илтгэсэн нь:

Сонгуулиар ардчилсан төрийг байгуулдаг ч гэсэн сонгууль нь улс төрийн үзэл санааны төлөө манлайллын тэмцэл, хүмүүс хоорондын тэмцэл, нийгэм улс төрийн лидерүүдийн хоорондын тэмцэл юм.

Сонгуулийн хурц өрсөлдөөнтэй нүсэр ажлыг сурталчлах, зохион байгуулахад багагүй мөнгө ордгийг Та бид мэднэ. Сонгуулийн санхүүжилт дотроо хоёр хэсгээс бүрддэг. Энд түүний нэг хэсэг болох сонгуульд нэр дэвшигчдийн болон оролцогч улс төрийн намын санхүүжилтийн асуудлыг хөндөн ярилцахаар Та бид цугларсан.

Энэ асуудал өнөө үед манай улсын төдийгүй дэлхийн олон улс оронд анхаарал татсан сэдвийн нэг болоод байна. Учир нь өдгөө дэлхий даяар авилгал, түүний дотор улс төрийн авилгалын хор аюулын талаар сэтгэл түгшин ярьж, цэвэр тунгалаг улс төрийг бий болгох, бохир мөнгө улс төрд орж буйг таслан зогсоох, түүнээс сэргэмжлэх арга замыг эрэлхийж байна.

Манай улсад явагдсан сонгуулиас харахад сонгуулийн кампанийн санхүүжилтийн өртөг зардал цаашид улам өсөн нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, намууд 1992 оны УИХ-ын сонгуульд 13 708 2 сая төгрөг, 1996 оныход 209 349,1 сая төгрөг, 2000 оны УИХ-ын сонгуульд 1 841 679,8 сая төгрөг зарцуулжээ. Энэ бол бас бүрэн бус мэдээ юм.

Зардал мөнгө ийнхүү өссөний шалтгааныг объектив, субъектив зүйлээр тайлбарлаж болох авч энэ тухай би ярих шаардлагагүй биз ээ. Сонгуулийн цаана нийгэм эдийн засгийн тодорхой бүлэглэлүүдийн эрх ашиг хамрагдах болсон. Сонгууль нь нэг ёсны өвөрмөц бизнес болж, сонгуулийн явцад гүйцэтгэх мөнгөний үүрэг хүчтэй болж байна. Улс төрийн албан тушаал нь эргээд бизнесийг санхүүгийн дэмжлэгээр хангах, энд хэлэхэд хэцүү бас бус оролцоогоор хангах хэрэгсэл болсон учраас санхүүгийн нэлээд дэмжлэг шаардаж байна. Мөнхүү албан тушаал нь захиалга хуваарилах, онцгой байдал олгох, элдэв хөнгөлөлт, тэр дотор татварын хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх, албан тушаал хуваарилах зэрэг хэлбэрээр эдийн засгийн ашиг өгч болдог тул бизнесийн хүрээнийхэн улс төрийн тавцанд өөр өөрийн байр суурийг тогтоох өрсөлдөөнийг өвөр хоорондоо явуулж, энд мөнгө их хэмжээгээр зарцуулагдах боллоо. Төрийн төсвийн мөнгө хөрөнгө ч шууд бусаар сонгуульд ашиглагдах тохиолдол гарч байна.

Нөгөө талаар сонгуулийн кампанийн зардал өсч байгаа нь улс төрийн намууд бодлогоо сонгогчдод итгүүлэн үнэмшүүлэхэд урьд урьдаас илүү түвэгтэй байдал бий болж байгаатай холбоотой. Амлалтаа бүрэн хэрэгжүүлээгүйгээс болон бас бус явдлаас болж намын нөлөө буурах нь хүмүүсийн сонгуульд оролцох идэвхийг сулруулахад нөлөөлж байгаа учраас нийтийн санаа бодлыг судлах, сурталчилгаа хийх зэрэгт ихээхэн мөнгө зарцуулахад хүрч байна. Менежмент, маркетингийн үүднээс сонгуулийн зах зээлийг судлах, задлан шинжлэхэд судалгааны ажлууд хийх болж бас мөнгө зарцуулагдах боллоо.

Улс төрийн намын сонгуулийн кампанийн санхүүжилтийн асуудлыг 10 минутад багтаад ярих нь бэрхтэй, тэгэхээр дараах тодорхой чиглэл дээр Та нөхдийн анхаарлыг төвлөрүүлэхийг хүсье.

1. Улс төрийн намын сонгуулийн бус үеийн болон сонгуулийн санхүүжилтийн тухайд. Улс төрийн намуудын тухай хуульд сонгуулийн бус үед нам санхүүгийнхээ тайланг Засгийн газарт тавихаар заасан нь бий. Шинэ төсөл хэмээн сонинд хэвлэгдсэн намуудын хуулийн төсөлд ч тэр хэвээрээ харагдана лээ. Энэ бол байж болохгүй заалт л даа. Яагаад вэ гэвэл олонхийн засгийн газар намуудын тайланг хянах нь. Гаднын туршлага гэж бид их ярьдаг. Энэ өнцгөөс авч үзвэл 2 үндсэн чиглэлтэй байна.

а) Нам сонгуулийн бус үед жилийн санхүүгийн тайлангаа хөндлөнгийн хувийн аудитын байгууллагаар баталгаажуулж дүгнэлт гаргуулж, сонгуулийн төв байгууллагадаа хүргүүлдэг.

Нийтэд зарладаггүй. Хяналт тавих үүднээс хараат бус сонгуулийн байгууллагад хүргүүлдэг юм. Тухайн намын санхүүжилттэй холбоотой ямар нэгэн асуудал сонгуулийн үед болон эрх барьж буй үед гарахад тэр тайлан нь хэрэг болдог байна.

б) Сонгуулийн санхүүгийн хяналтын албыг байгуулж жилд 1-2 удаа ажиллуулж тогтмол хугацаагаар намууд тэр албанд санхүүгийн тайлангаа өгдөг арга байна. Энэ байгууллага хүч хүрвэл санхүүгийн тайланд нь аудит хийдэг. Манайд ийм байгууллага Сонгуулийн ерөнхий хорооны дэргэд сонгуулийн үед байгуулж ажиллуулдаг л даа. Гэвч орон тооны бус энэ байгууллага хүч хүрдэггүй. Цаашид СЕХ, Төв банк, татвар, аудит, мэргэжлийн хяналтын газраас мэргэжлийн хүмүүс оруулан байгуулж ажиллуулж ч болох талтай юм. Гишүүд нь улсын байцаагчийн эрх эдэлдэг байх хэрэгтэй байх.

2. Манай өнөөгийн үйлчилж байгаа хуульд сонгуулийн үед сонгуульд оролцох нам эвсэл, бие дааж нэр дэвшигч нь сонгуулийн зардлын сан байгуулж банкид данс нээх, Сонгуулийн ерөнхий хороонд мэдэгдэх, нийтэд зарлахаар заасан байгаа. Сонгуулийн кампанийн үед цуглуулах хандив, сонгуульд зарцуулах хөрөнгөө энэ дансад хийж, уг дансаар дамжуулж зарцуулахаар хуульчилсан. Данснаас гадуур хандив авах, өгөх, зарцуулахыг хориглосон заалт бий.

Энэ заалт уг нь зөв заалт. Хэрэгжихэд маш бэрхшээлтэй. Хяналт тавихад ч бэрхшээлтэй. Ер нь банкаар дамжуулах нь зөв. Тэгвэл хяналт тавьж чадна. Харин намаар төдийгүй нэр дэвшигч бүрээр данс нээж, тэр дансад мөнгөө цуглуулах хэрэгтэй.

Сонгуулийн ерөнхий хороо, Төв банк хоёр энэ талаар тусгай журам гарган мөрдүүлж болох талтай. Мөнгөөс шимтгэл авахгүй байх талаар зааж ч болно. Бодит байдалд сонгуулийн зардлын 90-95, түүнээс дээш хувийг нэр дэвшигч гаргадаг шүү дээ. Энэ нь ямар ч хяналтгүй явдаг. Цуглуулсан мөнгөө бүрэн зарцуулж байна уу? үгүй юу гэдэгт ч сонгуулийн дараа хэл ам гардаг. Сонгогдохын төлөө бус, мөнгө олохын төлөө нэр дэвшсэн гэсэн утгатай яриа хөөрөө ч сонгуулийн дараа тодорхой хүн дээр гарч байсан удаа бий.

Аймгийн төвдөө, нэр дэвшсэн нутагтаа данс нээж болно. Үүнийг хэрхэхийг журмаар зохицуулж болох байх. Сумдад бэлэн мөнгө хэрэгтэй бол дансаас аваад л явна биз. Цуглуулсан мөнгөө хуулиар тодорхойлсон зардалд бус хүмүүсийн санал худалдаж авахад зарцуулж бэлэн мөнгө тараах, архи өгөх, хахуульдах явдал ч зарим нэр дэвшигч, нам дээр гардаг. Энэ болоцоог хаах, хяналт тавих, хэрэв ийм үйлдэл гарвал нэн даруй арга хэмжээ авахыг сайн хуульчилмаар байгаа юм.

3. Бүх төрлийн хандивын хэмжээнд хязгаарлалт тогтоох нь зүйтэй мэт санагддаг. Хязгаарлалтыг хэрхэн тогтоох вэ? Хандивыг тооны хувьд аль болох олон этгээдээс авахаар хязгаарлалт тогтоох нь зөв юм шиг. Амьдрал дээр харж байхад цөөн тооны этгээдээс ихээхэн мөнгө авсан бол дараа нь тэр этгээдийн нөлөөнд автах явдал гарч байна. Бага багаар олон эх үүсвэрээс бүрдүүлбэл төрийн бодлого явуулахад нөлөөнд автах, тэр мөнгийг ямар нэгэн хэлбэрээр буцааж төлөх бодлоос нэр дэвшигч ангижирч болно. Нөгөө талаар хандивлагч этгээдийн зүгээс төр засгийн бодлогод нөлөөлөх гэсэн оролдлого ч багасна. Иймд нэг этгээдээс авах мөнгөний дээд хязгаар, бэлнээр авах мөнгөний тоо хэмжээг зааж хуульчлах нь чухал. Аль алиныг их биш бага мөнгөний дүнгээр хуульчилан заавал зүгээр санагддаг. АНУ-д бэлнээр 100 ам.доллар авахыг зөвшөөрсөн байдаг.

Хандивлагчид нэрээ гаргахгүй байхыг хичээх, аль аль талд хандив өгөх явдал гардаг. Манай хуулиар хандивлагчдыг нэрээр нь, өгсөн мөнгөний хэмжээтэй нь намууд тайлан гаргах заалт байхгүй. Уул нь ийм заалт оруулвал зүйтэй байх. Тэгээд хандивт тодорхой хязгаарлалт тогтоож хуульчлах нь зөв байх.

4. Хандив ямар этгээдээс авч болох, ямар этгээдэс авч болохгүйг нарийн заах нь чухал. Манай хуульд энэ талаар заалт бий. Гэхдээ их бүрхэг. Бүрхэг гэдэг нь жишээлбэл: сонгуульд зарцуулж болох хөрөнгө нь:

- а) Өөрийн хөрөнгө
- б) Хуулийн этгээд хувийн байгууллагын хандив
- в) Иргэдийн хандив зэрэг болно.

Нэр дэвшигч өөрийн хөрөнгөнд оруулсан орлогоо эх үүсвэрээр тодорхойлох ёстой. Бүртгүүлэхдээ тойргийн, эсхүл СЕХ-нд гаргаж өгдөг болох нь зүйтэй байх. Ингэх нь ямар мөнгө сонгуульд зарцуулагдаж буйг хянахад бололцоо олгоно.

Байгууллагаас гэдэг нь мэдээж **хувийн** компани, хоршоо, нөхөрлөлөөс авах мөнгө. Ямар шийдвэрээр, яаж өгөх, хэн өгөх, ямар журмаар өгөх нь их тодорхойгүй. АНУ-д бол хувийн байгууллага хандив өгөхөөр бол улс төрийн хороо байгуулж тусгай данс нээж тэнд мөнгөө төвлөрүүлж дүрмийн сангийн бус өөр эх үүсвэрээс шилжүүлдэг. Энэ зөв. Шууд компанийн хөрөнгө мөнгөнөөс нэг этгээд мэдээд өгчихдөггүй юм.

Иргэдээс: Иргэний хөрөнгө мөнгө бол голдож хамтын хөрөнгө мөнгө байдаг. Орон сууцаа, байраа худалдаад, машинаа зараад өгчих ч юм уу? аль эсхүл ихээхэн мөнгө өгөхөд татвар тооцсон уу, үгүй юу? шударга мөнгө үү, үгүй юу? гэдэгт хяналт тавих учиртай. Сонгуулийн дараа хэл ам татлах явдал гардаг. Бас нэр дэвшигч гаднын хүнээс, гаднын байгууллагаас мөнгө авч нууцаар ашиглах явдал гардаг. Энэ бол бүр байж болохгүй, хуулиар хатуу хорих асуудал.

Нэр дэвшигч банкны зээлийн мөнгө ашиглаж бас болохгүй. Нэр дэвшигч бүрээр банкнаас зээл авсан эсэхийн баталгаа гаргуулж нэр дэвшигчийг бүртгэдэг журамд шилжих учиртай. Улсын төсвөөс, тусламжийн бараа, эд агуурс борлуулж хандив өгөхийг эрс хориглох нь зөв.

5. Сонгуульд нэг нэр дэвшигчийн зарцуулах мөнгөнд хязгаарлалт тогтоох уу? үгүй юу? Хуульчид хүний эрх зөрчиж байна гэдэг. Миний бодлоор хязгаарлалт тогтоох нь зөв. Энэ нь:

- a) Мөнгөний хэт нөлөөнөөс улс төрчдийг хамгаалах,
- b) Нэр дэвшигч бүрийг адил тэгш өрсөлдөөнд байлгах
- c) Сонгуулийг хөрөнгө чинээний өрсөлдөөн биш, тэгш нөхцөл бүрдүүлсэн өрсөлдөөн болгоход тустай.

Азийн орнуудад тодорхой хязгаарлалт тогтоодог. Орос оронд, ихэнх хөгжиж байгаа оронд тодорхой хязгаарлалт тогтоодог. Харин АНУ-д түүнийг тогтоодоггүй. Манайд 1992 оны сонгуульд нэг нэр дэвшигчид 49,8 мянган төгрөг ногдож байсан бол 1996 оныход 693,2; 2000 оныход 3 885,4 мянган төгрөг ногдож их өссөн. Энд тэгш өрсөлдөөн явагдаагүй. Дээрх тоо бол дундаж тоо. Хүн бүрээр авч үзэж гаргавал сонин тоо гарна.

6. Сонгуулийн зардлыг ил тод байлгах, хянах, мэдээлэх журмын тухай.

Манайд сонгуулийн хуулиар сонгууль дууссанаас хойш сарын дотор Сонгуулийн ерөнхий хороонд намууд тайлангаа өгөх заалттай. Энэ заалт бүрэн хэрэгжихгүй байсан. Хариуцлагыг сонгуулийн хуульд суулгаж өгөх ёстой. Зардлыг хянахад цэвэр, бохир мөнгө алин болохыг хянахад хэцүү. Энэ талын хуулийн заалтыг тодруулах, авах арга хэмжээ нь тодорхой байх ёстой. Хандивлагчдыг нэрээр, өгсөн мөнгөний тоотой нь нийтэд зарладаг болгох нь зөв.

7. Сонгуулийн санхүүжилтийн талаар хууль зөрчсөн бол авах арга хэмжээ нь их тодорхой байх ёстой. Энэ талаар манай хууль дутагдалтай. Цаг хугацааны ач холбогдол өнгөрсний дараа, өөрөөр хэлбэл сонгуулийн дараашүүхээр ёс төдий шийдвэрлэх заалт голлосон буй.

8. Эцэст нь хэлэхэд мөнгө хөрөнгөтэй орнууд сонгуулийг төсвөөс санхүүжүүлэх чиглэл барьж байна. Манайд ойрдоо чадахгүй байх. Яваандаа Ерөнхийлөгчийн сонгуулиас эхлэн төсвөөс санхүүжүүлэх чиглэл барих нь зөв. Мөн сонгуулийн үед хэвлэл, мэдээллийн байгууллага, урлагийн байгууллагынханд нийгмийн баялаг ихээр хуваарилагдаж байгаа байдлыг ч сонгуулийн хууль тогтоомжоор зохицуулах ёстой байх.

Баярлалаа.